



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 1/712

Булган сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны IX/19 дүгээр тогтоолоор баталсан "Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Б.Батбаатар (ГЭ68091017)-ын Булган сум 6 дугаар баг Залуус 2 дугаар гудамж 217 тоотод байршилтай 6308002768 нэгж талбар бүхий амины орон сууцны зориулалтаар эзэмшиж буй 955 м2 газар, Ж.Лхамсүрэн (ГЭ48060206)-гийн Булган сум 5 дугаар баг Хатанбаатар С.Магсаржав 2 дугаар гудамж 270 тоотод байршилтай 6308003654 нэгж талбар бүхий худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 1326 м2 газар, Н.Хишигжаргал (ШГ71032874)-ын Булган сум 5 дугаар баг Хатанбаатар С.Магсаржав 2 дугаар гудамж 218 тоотод байршилтай 6308003618 нэгж талбар бүхий худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 192 м2, "Сүүдэрцарам" ХХК (РД:2007525)-ийн Булган сум 5 дугаар баг Хатанбаатар С.Магсаржав 2 дугаар гудамж 227 тоотод байршилтай 6308006998 нэгж талбар бүхий худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 998 м2 газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг тус тус 15 жилээр сунгасугай.

2. Б.Батбаатар, Ж.Лхамсүрэн, Н.Хишигжаргал, "Сүүдэрцарам" ХХК-ийн захирал Ч.Жамбалдорж нартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг дээрх 3 иргэн, 1 аж ахуйн нэгжид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Засахирамж

6324011004